



GOETHE-ZERTIFIKAT B1

DURCHFÜHRUNGSBESTIMMUNGEN ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Stand: 1. September 2025

2025 оны 9-р сарын 1-ний байдлаар

Zertifiziert durch
Баталгаажуулсан



**GOETHE
INSTITUT**

Sprache. Kultur. Deutschland.

Durchführungsbestimmungen zur Prüfung GOETHE-ZERTIFIKAT B1 für Erwachsene und Jugendliche

Stand: 1. September 2025

Die *Durchführungsbestimmungen* zur Prüfung GOETHE-ZERTIFIKAT B1 für Erwachsene und Jugendliche sind Bestandteil der *Prüfungsordnung des Goethe-Instituts* in ihrer jeweils aktuellen Fassung.

Die *Durchführungsbestimmungen* beschreiben die Bestandteile der einzelnen Prüfungen und regeln die prüfungsspezifischen Bedingungen der Prüfungsorganisation, des Ablaufs und der Bewertung sowie die Berechnung der Prüfungsergebnisse.

Das GOETHE-ZERTIFIKAT B1 wurde gemeinsam entwickelt vom Goethe-Institut, dem ÖSD und dem Bereich Mehrsprachigkeitsforschung und Fremdsprachendidaktik/Deutsch als Fremdsprache der Universität Fribourg/Schweiz. Die Prüfung wird an den in § 2 der *Prüfungsordnung* genannten Prüfungszentren weltweit nach einheitlichen Kriterien durchgeführt und bewertet.

Die Prüfung dokumentiert die dritte Stufe – B1 – der im *Gemeinsamen europäischen Referenzrahmen für Sprachen (GER)* beschriebenen sechsstufigen Kompetenzskala und damit die Fähigkeit zur selbstständigen Sprachverwendung.

§ 1 Prüfungsbeschreibung

Siehe hierzu auch *Prüfungsordnung* § 1.

1.1 Bestandteile der Prüfung

Die Prüfung GOETHE-ZERTIFIKAT B1 für Erwachsene und Jugendliche besteht aus vier Modulen, die einzeln oder in Kombination abgelegt werden können:

- drei schriftliche Module als Gruppenprüfung: LESEN, HÖREN, SCHREIBEN,
- ein mündliches Modul als Paar- oder (in Ausnahmefällen) Einzelprüfung: SPRECHEN.

Насанд хүрэгчид ба өсвөр насныханд зориулсан GOETHE-ZERTIFIKAT B1 шалгалт зохион байгуулах журам

2025 оны 9-р сарын 1-ний байдлаар

Насанд хүрэгчид ба өсвөр насныханд зориулсан GOETHE-ZERTIFIKAT B1 шалгалт зохион байгуулах тухайн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам нь Гёте-Институтийн шалгалтын журмын нэг хэсэг юм.

Шалгалт зохион байгуулах журамд шалгалт тус бүрийн бүрэлдэхүүн хэсгийг тайлбарлахаас гадна шалгалтын байгууллага, шалгалтын явц, үнэлгээ, үр дүнг тооцох зэрэгт үүсэх шалгалттай холбоотой онцгой нөхцөлүүдийг уг журмаар зохицуулна.

GOETHE-ZERTIFIKAT B1 шалгалтыг Гёте-Институт, АХД (ÖSD) мөн Швейцарийн Фрибургийн их сургуулийн гадаад хэл/Герман хэл заах арга зүй болон олон хэлний судалгааны алба хамтран боловсруулж гаргасан юм. Энэхүү шалгалтыг шалгалтын журмын § 2-т дурдсан шалгалтын төвүүдэд дэлхий даяар нэгдсэн шалгуурын дагуу зохион байгуулж, үнэлдэг.

Энэхүү шалгалт нь 6 түвшин бүхий европын хэлний нэгдсэн стандартын гурав дахь түвшин болох B1 буюу хэлний бие даасан хэрэглээ эзэмшсэн талаарх чадварыг гэрчилнэ.

§ 1 Шалгалтын тайлбар

Шалгалтын журмын § 1 дэх заалтыг харна уу.

1.1 Шалгалтын бүрэлдэхүүн хэсгүүд

Насанд хүрэгчид болон өсвөр насныханд зориулсан GOETHE-ZERTIFIKAT B1 шалгалт нь дангаар болон хослуулан өгөх боломжтой 4 хэсэг буюу модулиас бүрдэнэ. Үүнд:

- Бүлгээр өгөх бичгийн шалгалтын 3 хэсэг: УНШИХ, СОНСОХ, БИЧИХ
- Хосоор болон ганцаарчилж (онцгой тохиолдолд) өгөх аман шалгалтын хэсэг: ЯРИХ.

1.2 Prüfungsmaterialien

Die Prüfungsmaterialien bestehen aus *Kandidatenblättern* mit Antwortbögen (*Lesen, Hören, Schreiben*), *Prüferblättern* mit den Bögen *Schreiben – Bewertung, Sprechen – Bewertung, Schreiben – Ergebnis, Sprechen – Ergebnis* sowie einer Audiodatei.

Die *Kandidatenblätter* enthalten die Aufgaben für die Prüfungsteilnehmenden:

- Texte und Aufgaben zum Modul LESEN (Teil 1–5);
- Aufgaben zum Modul HÖREN (Teil 1–4);
- Aufgaben zum Modul SCHREIBEN (Teil 1–3);
- Aufgaben zum Modul SPRECHEN (Teil 1–3, für Teil 2 jeweils zwei Themen zur Wahl).

In die Antwortbögen tragen die Prüfungsteilnehmenden ihre Lösungen bzw. ihren Text ein. Für die Module SCHREIBEN und SPRECHEN wird den Prüfungsteilnehmenden vom Prüfungszentrum gestempeltes Konzeptpapier zur Verfügung gestellt.

Die *Prüferblätter* enthalten für

- das Modul LESEN die Lösungen,
- das Modul HÖREN die Transkriptionen der Hörtexte und die Lösungen,
- die Module SCHREIBEN und SPRECHEN die Kriterien zur Bewertung der Leistungen,
- das Modul SCHREIBEN Hinweise zur Durchführung und Bewertung sowie pro Aufgabe jeweils zwei Leistungsbeispiele für das Niveau B1 und die Bewertungskriterien,
- das Modul SPRECHEN Hinweise zur Gesprächsführung und Moderation sowie die Bewertungskriterien.

In die Antwortbögen *Lesen* und *Hören* bzw. in die Bögen *Schreiben – Bewertung* und *Sprechen – Bewertung* tragen die Prüfenden ihre Bewertung ein. Die Ergebnisse werden jeweils auf die Bögen *Schreiben – Ergebnis* und *Sprechen – Ergebnis* übertragen.

Die Audiodatei enthält die Texte zum Modul HÖREN sowie alle Anweisungen und Informationen.

1.2 Шалгалтын материалууд

Шалгалтын материал нь хариултын хуудас бүхий шалгалтын хуудас (унших, сонсох, бичих), Бичих-Үнэлгээний хуудас, Ярих-Үнэлгээний хуудас, Бичих-Дүнгийн хуудас, Ярих-Дүнгийн хуудас бүхий шалгагчийн хуудас болон аудио файл зэргээс бүрдэнэ.

Шалгалтын хуудас нь шалгалтад оролцогчдод зориулсан дараах даалгавруудыг агуулна. Үүнд:

- УНШИХ хэсгийн даалгаврууд ба эхүүд (1-5 хэсэг)
- СОНСОХ хэсгийн даалгаврууд (1-4 хэсэг)
- БИЧИХ хэсгийн даалгаврууд (1-3 хэсэг)
- ЯРИХ хэсгийн даалгаврууд (1-3 хэсэг, 2-р хэсэгт хоёр сэдвээс сонгоно)

Шалгуулагч нь хариултын хуудаст өөрийн бичсэн эх болон хариултаа бичнэ. БИЧИХ, ЯРИХ хэсгүүд дээр шалгалтын төвөөс тамгалсан ноорог цаасыг шалгуулагчдад тарааж өгнө.

Шалгагчийн хуудас нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- УНШИХ хэсгийн хариунууд
- СОНСОХ хэсгийн хариунууд ба сонсох эхийн хөрвүүлсэн бичвэрүүд,
- БИЧИХ, ЯРИХ хэсгийн яриа, бичгийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурууд,
- БИЧИХ хэсгийг зохион явуулах журам, үнэлэх заавар болон даалгавар бүрт B1 түвшний гүйцэтгэлийн хоёр жишээ, үнэлгээний шалгуурууд
- ЯРИХ хэсгийн явцыг удирдах, яриаг хөтлөн явуулах заавар болон үнэлгээний шалгуурууд

Унших ба Сонсох хариултын хуудас дээр буюу, Бичих-Үнэлгээний хуудас, Ярих-Үнэлгээний хуудсанд шалгагчид үнэлгээгээ бичнэ. Бичих-Дүнгийн хуудас, Ярих-Дүнгийн хуудсанд дүнгээ бичиж оруулна.

Аудио файл нь СОНСОХ хэсгийн эхүүд болон бүх заавар, мэдээллийг агуулна.

1.3 Module

Die Materialien liegen als vier Module vor. Die Module können einzeln oder in Kombination abgelegt werden.

1.4 Zeitliche Organisation

Bei Ablegen aller vier Module an einem Prüfungstermin finden die schriftlichen Module als Gruppenprüfung in der Regel vor dem mündlichen Modul statt.

Die schriftlichen Module dauern ohne Pausen insgesamt circa 165 Minuten:

Modul	Dauer
LESEN	65 Minuten
HÖREN	ca. 40 Minuten
SCHREIBEN	60 Minuten
Gesamt	ca. 165 Minuten

Das Modul SPRECHEN wird in der Regel als Paarprüfung durchgeführt, in Ausnahmefällen ist auch eine Einzelprüfung möglich. Eine Paarprüfung dauert circa 15 Minuten, eine Einzelprüfung dauert circa 10 Minuten. Zur Vorbereitung auf die mündliche Prüfung erhalten die Teilnehmenden sowohl für die Paar- als auch für die Einzelprüfung 15 Minuten Zeit.

Für Prüfungsteilnehmende mit spezifischem Bedarf können die angegebenen Zeiten verlängert werden. Einzelheiten sind in den *Ergänzungen zu den Durchführungsbestimmungen: Prüfungsteilnehmende mit spezifischem Bedarf* geregelt.

1.5 Protokoll über die Durchführung der Prüfung

Über die Durchführung der Prüfung wird ein Protokoll geführt, das besondere Vorkommnisse während der Prüfung festhält und mit den Prüfungsergebnissen archiviert wird.

1.3 Шалгалтын хэсгүүд буюу модулиуд

Материалууд 4 хэсэг буюу модуль тус бүрээр байна. Энэхүү шалгалтын хэсгүүдийг дангаар нь болон хослуулан өгч болно.

1.4 Цагийн зохион байгуулалт

Шалгалтын нэг товд бүх 4 хэсгийг өгөх тохиолдолд бичгийн хэсгүүд гол төлөв ярианы шалгалтын өмнө бүлгийн шалгалт хэлбэрээр явагдана.

Бичгийн хэсгүүд завсарлагагүйгээр нийт 165 минут орчим үргэлжилнэ:

Хэсгүүд	Үргэлжлэх хугацаа
УНШИХ	65 минут
СОНСОХ	40 минут орчим
БИЧИХ	60 минут
Нийт	165 минут орчим

ЯРИХ хэсгийг гол төлөв хос шалгалт хэлбэрээр зохион байгуулдаг ба онцгой тохиолдолд ганцаарчилсан хэлбэрээр явуулж болно. Хосоор өгөх шалгалт 15 минут, ганцаарчилсан шалгалт 10 минут үргэлжилнэ. Ярианы шалгалтын бэлдэх хугацаа хосоор болон ганцаарчилж өгөх аль ч тохиолдолд 15 минут байна.

Тусгай хэрэгцээт шалгуулагчдад өгөгдсөн хугацааг сунгаж өгч болно. Дэлгэрэнгүйг Шалгалт зохион байгуулах журмын нэмэлт заалтууд: Тусгай хэрэгцээт шалгуулагчдын зохицуулалт хэсэгт тусгасан болно.

1.5 Шалгалтын явцын талаарх протокол

Шалгалт зохион байгуулах үед гарсан онцгой тохиолдлуудыг тэмдэглэн протокол хөтөлж шалгалтын дүнтэй хамт архивлана.

§ 2 Die schriftlichen Module LESEN, HÖREN und SCHREIBEN

Werden die drei schriftlichen Module an einem Prüfungstermin angeboten, wird folgende Reihenfolge empfohlen: LESEN – HÖREN – SCHREIBEN. Aus organisatorischen Gründen kann diese Reihenfolge vom jeweiligen Prüfungszentrum geändert werden.

Zwischen jedem dieser Module ist eine Pause von mindestens 15 Minuten vorzusehen.

2.1 Vorbereitung

Vor dem Prüfungstermin bereitet der/die Prüfungsverantwortliche unter Beachtung der Geheimhaltung die Prüfungsmaterialien vor. Dazu gehört auch eine inhaltliche Überprüfung inklusive der Audiodatei sowie deren Funktionalität.

2.2 Ablauf

Vor Beginn des jeweiligen Moduls weisen sich alle Teilnehmenden aus. Die Aufsichtsperson gibt danach alle notwendigen organisatorischen Hinweise.

Vor Beginn der jeweiligen Module werden die entsprechenden *Kandidatenblätter* und Antwortbögen sowie bei Bedarf gestempeltes Konzeptpapier ausgegeben.

Die Teilnehmenden tragen alle erforderlichen Daten auf Antwortbögen und Konzeptpapier ein; erst dann beginnt die eigentliche Prüfungszeit.

Die *Kandidatenblätter* zum jeweiligen Modul werden ohne Kommentar ausgegeben; alle Aufgabenstellungen sind auf den *Kandidatenblättern* erklärt.

Am Ende des jeweiligen Moduls werden alle Unterlagen, auch das Konzeptpapier, eingesammelt. Beginn und Ende der Prüfungszeit werden jeweils in geeigneter Form von der Aufsichtsperson mitgeteilt.

§ 2 Бичгийн хэсгүүд УНШИХ, СОНСОХ, БИЧИХ

Бичгийн 3 хэсгийг шалгалтын нэг товд авах бол УНШИХ - СОНСОХ - БИЧИХ гэсэн дарааллаар явуулахыг зөвлөдөг. Тухайн шалгалтын төв нь зохион байгуулалтын улмаас энэ дарааллыг өөрчилж болно.

Шалгалтын хэсэг тус бүрийн хооронд хамгийн багадаа 15 минутын завсарлага төлөвлөнө.

2.1 Бэлтгэл

Шалгалтын товын өмнө шалгалт хариуцсан ажилтан нууцлалыг чанд сахин шалгалтын материалыг бэлтгэнэ. Мөн шалгалтын материал, аудио файлын агуулгын үнэн зөв байдлыг, саадгүй ажиллаж байгаа эсэхийг нягтална.

2.2 Шалгалтын явц

Тухайн шалгалтын хэсэг тус бүр эхлэхээс өмнө бүх шалгуулагчид бичиг баримтаа шалгуулна. Дараа нь хянагч зохион байгуулалттай холбоотой шаардлагатай бүх мэдээллийг өгнө.

Шалгалтын хэсэг тус бүр эхлэхээс өмнө холбогдох шалгалтын хуудас, хариултын хуудас болон шаардлагатай тохиолдолд тамгалсан ноорог цаасыг тарааж өгнө.

Шалгуулагчид хариултын хуудас, ноорог цаасанд шаардлагатай бүх мэдээллийг бөглөж дууссанаар шалгалтын хугацаа эхэлнэ.

Бүх даалгаврыг шалгалтын хуудсанд дэлгэрэнгүй тайлбарласан байдаг тул хэсэг бүрийн шалгалтын хуудсыг нэмэлт тайлбаргүйгээр тараана. Хэсэг бүрийн төгсгөлд бүх материалууд болон ноорог цаасыг хураан авна. Хянагч шалгалтын эхлэх, дуусах цагийг ойлгомжтой байдлаар мэдэгдэнэ.

Für das Ablegen der drei schriftlichen Module an einem Prüfungstermin gilt folgender Ablauf:

1. Die Prüfung beginnt in der Regel mit dem Modul LESEN. Die Teilnehmenden markieren ihre Lösungen auf den *Kandidatenblättern* und übertragen sie am Ende auf den Antwortbogen *Lesen*. Für das Übertragen ihrer Lösungen planen die Teilnehmenden circa 5 Minuten innerhalb der Prüfungszeit ein.
2. Nach einer Pause wird in der Regel das Modul HÖREN durchgeführt. Die Audiodatei wird von der Aufsichtsperson gestartet. Die Teilnehmenden markieren ihre Lösungen zunächst auf den *Kandidatenblättern* und übertragen sie am Ende auf den Antwortbogen *Hören*. Für das Übertragen ihrer Lösungen stehen den Teilnehmenden circa 5 Minuten innerhalb der Prüfungszeit zur Verfügung.
3. Danach bearbeiten die Teilnehmenden in der Regel das Modul SCHREIBEN. Den Text verfassen die Teilnehmenden direkt auf dem Antwortbogen *Schreiben*. Falls die Teilnehmenden den Text zunächst auf Konzeptpapier verfassen, planen sie für das Übertragen ihres Textes auf den Antwortbogen *Schreiben* ausreichend Zeit innerhalb der Prüfungszeit ein.

§ 3 Das Modul SPRECHEN

Das Einführungsgespräch einschließlich Vorstellung der Prüfenden und des/der Teilnehmenden dauert circa eine Minute.

Teil 1 dauert circa 2-3 Minuten, Teil 2 circa 3-4 Minuten pro PTN und Teil 3 circa 1-2 Minuten pro PTN.

Die gesamte Prüfung dauert also circa 15 Minuten (Paarprüfung) bzw. 10 Minuten (Einzelprüfung).

3.1 Organisation

Für die Prüfung steht ein geeigneter Raum zur Verfügung. Tisch- und Sitzordnung werden so gewählt, dass eine freundliche Prüfungsatmosphäre entsteht. Die Zusammenstellung der Teilnehmenden der Paarprüfung erfolgt nach dem Zufallsprinzip.

Бичгийн 3 хэсгийг шалгалтын нэг товд өгөх бол дараах дарааллаар явагдана:

1. Шалгалт гол төлөв УНШИХ хэсгээр эхэлнэ. Шалгуулагчид эхлээд шалгалтын хуудсан дээр хариугаа тэмдэглээд төгсгөлд нь Унших-хариултын хуудсан дээр тэмдэглэнэ. Шалгуулагчид шалгалтын цагт багтаан ойролцоогоор 5 минутыг хариулгаа хариултын хуудсанд буулгахаар төлөвлөнө.
2. Завсарлагааны дараа гол төлөв СОНСОХ хэсэг явагдана. Хянагч нь аудио файлыг тоглуулж эхэлнэ. Шалгуулагчид эхлээд шалгалтын хуудсан дээр хариугаа тэмдэглээд төгсгөлд нь Сонсох-хариултын хуудсан дээр тэмдэглэнэ. Оролцогчдод хариугаа буулган бичихэд шалгалтын хугацаанаас ойролцоогоор 5 минут ноогдоно.
3. Дараа нь шалгуулагчид БИЧИХ хэсгийн даалгавруудыг гүйцэтгэнэ. Шалгуулагчид эхээ Бичих-хариултын хуудсан дээр шууд бичнэ. Шалгуулагчид эхээ эхлээд ноорог цаасан дээр зохиож бичих тохиолдолд түүнийгээ Бичих -хариултын хуудас руу буулгаж бичих хангалттай цагийг шалгалтын хугацаанд багтаан төлөвлөх хэрэгтэй.

§ 3 ЯРИХ хэсэг

Шалгагч болон шалгуулагчдын оршил болон танилцах яриа нэг минут орчим үргэлжилнэ.

Шалгуулагч бүрийн хувьд 1-р хэсэг 2-3 минут орчим, 2-р хэсэг 3-4 минут орчим, 3-р хэсэг 1-2 минут орчим үргэлжилнэ.

Шалгалт хосоор өгч буй тохиолдолд нийт 15 минут орчим, ганцаарчилж өгч буй тохиолдолд 10 минут орчим үргэлжилнэ.

3.1 Зохион байгуулалт

Шалгалтад тохиромжтой өрөөг бэлдэж, ширээ, сандлыг таатай уур амьсгал бүрдүүлэх байдлаар байрлуулна. Аман шалгалтын хосоор өгөх бүлгийн хуваарилалт санамсаргүй байдлаар хийгдэнэ.

Wie bei allen anderen Modulen muss die Identität des/der Teilnehmenden vor Beginn des Moduls SPRECHEN, gegebenenfalls auch während des Moduls SPRECHEN, zweifelsfrei festgestellt werden.

3.2 Vorbereitung

Für die Vorbereitung steht ein geeigneter Raum zur Verfügung. Die Aufsichtsperson gibt den Teilnehmenden ohne Kommentar die *Kandidatenblätter* für das Modul SPRECHEN; alle Aufgabenstellungen sind auf den *Kandidatenblättern* vermerkt. Für Notizen steht gestempeltes Konzeptpapier zur Verfügung. Die Teilnehmenden dürfen ihre in der Vorbereitungszeit erstellten stichpunktartigen Notizen während des Moduls SPRECHEN verwenden.

3.3 Ablauf

Das Modul SPRECHEN wird von zwei Prüfenden durchgeführt. Eine/-r der Prüfenden moderiert das Prüfungsgespräch.

Bei Aufgabe 3 gibt der/die andere Prüfende Rückmeldung und stellt eine Frage. Beide Prüfenden machen Notizen und bewerten die Prüfungsleistungen unabhängig voneinander.

Für das Modul SPRECHEN gilt folgender Ablauf:

Zu Beginn begrüßen die Prüfenden die Teilnehmenden und stellen sich selbst kurz vor. Der/Die Moderator/-in führt ein kurzes Gespräch mit den Prüfungsteilnehmenden zum Kennenlernen. Die Prüfenden erläutern vor jedem Prüfungsteil kurz die Aufgabenstellung.

1. In Teil 1 planen die Teilnehmenden etwas gemeinsam. Im Fall einer Einzelprüfung übernimmt eine/-r der Prüfenden die Rolle des Gesprächspartners/der Gesprächspartnerin.
2. In Teil 2 präsentieren die Teilnehmenden nacheinander ein Thema. Im Fall einer Einzelprüfung hält nur der/die Teilnehmende einen kurzen Vortrag.

Бичгийн шалгалтын бусад хэсгүүдийн адил аман шалгалт эхлэхээс өмнө, мөн шаардлагатай тохиолдолд аман шалгалтын үеэр шалгуулагчийн мөн эсэхийг эргэлзээгүйгээр тодорхойлсон байх ёстой.

3.2 Бэлтгэл

Бэлтгэл хийхэд тохиромжтой өрөөг бэлдэнэ. Бүх даалгавар шалгалтын хуудсан дээр тэмдэглэгдсэн байгаа учир хянагч ЯРИХ хэсгийн шалгалтын хуудсыг тайлбаргүйгээр шалгуулагчдад тарааж өгнө; Тэмдэглэгээ хийхэд зориулж тамгалсан ноорог цаасыг мөн өгнө. Шалгуулагчид нь бэлтгэлийн хугацаанд түлхүүр үгээр хийсэн тэмдэглэлээ ЯРИХ хэсгийн үеэр ашиглаж болно.

3.3 Шалгалтын явц

ЯРИХ хэсгийг хоёр шалгагч авах бөгөөд нэг нь шалгалтыг хөтлөн явуулна.

Даалгавар 3 дээр хоёр шалгагчийн нэг нь тайлбар хийж, асуулт асууна. Хоёр шалгагч тэмдэглэгээ хийж шалгалтын гүйцэтгэлийг бие биеэс үл хамааран тус тусын үнэлгээг өгнө.

ЯРИХ хэсэг дараах дарааллаар явагдана:

Шалгалтын эхэнд шалгагчид шалгуулагчидтай мэндлээд өөрсдийгөө товч танилцуулна. Хөтлөгч шалгуулагчидтай танилцах богино ярилцлага хийнэ. Шалгалтын хэсэг бүрийн өмнө шалгагчид даалгаврыг товч тайлбарлана.

1. 1-р хэсэгт шалгуулагчид ямар нэгэн зүйлийг хамтдаа төлөвлөнө. Ганцаарчилсан шалгалтын үед шалгагчийн аль нэг нь ярианы хамтрагчийн үүргийг гүйцэтгэнэ.
2. 2-р хэсэгт шалгуулагчид ээлжлэн нэг сэдвийн хүрээнд богино илтгэл тавина. Ганцаарчилсан шалгалтын үед зөвхөн тухайн шалгуулагч л илтгэлээ тавина.

3. In Teil 3 geben der/die andere Teilnehmende und der/die zweite Prüfende, die bei der Präsentation zugehört haben, Rückmeldung zu dem Gehörten und stellen Fragen. Der/Die Teilnehmende, der/die den Vortrag gehalten hat, beantwortet diese Fragen. Im Fall einer Einzelprüfung stellt nur der/die Prüfende Fragen zum Vortrag.

Am Ende der Prüfung werden alle Unterlagen, auch das Konzeptpapier, eingesammelt.

§ 4 Bewertung schriftliche Module

Die Bewertung der schriftlichen Module findet im Prüfungszentrum oder in ausgewiesenen Diensträumen statt. Die Bewertung erfolgt jeweils durch zwei unabhängig Bewertende. Die Ergebnisse aus den schriftlichen Modulen werden nicht an die Prüfenden des Moduls SPRECHEN weitergegeben.

4.1 Modul LESEN

Im Modul LESEN gibt es 30 Items. Jedes Item ist ein Messpunkt. Pro Messpunkt und Lösung werden entweder 1 Punkt oder 0 Punkte vergeben.

Das Ergebnis wird auf 100 Ergebnispunkte umgerechnet. Dazu werden die erreichten Messpunkte mit 3,33 multipliziert und das Ergebnis jeweils gerundet:

Messpunkte	30	29	28	27	26	25	24	23	22	21
Ergebnispunkte	100	97	93	90	87	83	80	77	73	70

Messpunkte	20	19	18	17	16	15	14	13	12	11
Ergebnispunkte	67	63	60	57	53	50	47	43	40	37

Messpunkte	10	9	8	7	6	5	4	3	2	1	0
Ergebnispunkte	33	30	27	23	20	17	13	10	7	3	0

Die erzielten Ergebnisse werden in den Antwortbogen *Lesen* eingetragen, der von beiden Bewertenden gezeichnet wird.

3. 3-р хэсэгт шалгуулагч ба хоёр дах шалгагч сонссон илтгэлд эргэх мэдээлэл өгч, асуулт тавина. Илтгэл тавьсан шалгуулагч эдгээр тавьсан асуултад хариулна. Ганцаарчилсан шалгалтын үед зөвхөн шалгагч асуулт тавина.

Шалгалтын төгсгөлд бүх материалуудыг ноорог цаасын хамт хураан авна.

§ 4 Бичгийн шалгалтын хэсгүүдийг дүгнэх

Бичгийн шалгалтын хэсгүүдийн үнэлгээг шалгалтын төв эсвэл тусгай зориулалтын өрөөнд хийнэ. Үнэлгээг хоёр шалгагч бие биеэсээ үл хамааран тус бүрдээ хийнэ. Бичгийн хэсгүүдийн дүнг ЯРИХ хэсгийн шалгагч нарт дамжуулахгүй.

4.1 УНШИХ хэсэг

УНШИХ хэсэг 30 даалгавартай. Даалгавар бүр нь нэг хэмжих нэгж. Хэмжих нэгж ба хариулт бүрт 1 эсвэл 0 оноо өгнө.

Дүнг 100 оноонд шилжүүлэн бодно. Ингэхдээ авсан хэмжих нэгжүүдийг 3.33-аар үржүүлж гарсан тоог бүхэлчлэн тооцно.

Хэмжих нэгж	30	29	28	27	26	25	24	23	22	21
Оноо	100	97	93	90	87	83	80	77	73	70

Хэмжих	20	19	18	17	16	15	14	13	12	11
Оноо	67	63	60	57	53	50	47	43	40	37

Хэмжих нэгж	10	9	8	7	6	5	4	3	2	1	0
Оноо	33	30	27	23	20	17	13	10	7	3	0

Гарсан оноог Унших-хариултын хуудсанд буулгаж, хоёр шалгагч гарын үсэг зурна.

4.2 Modul HÖREN

Im Modul HÖREN gibt es 30 Items. Jedes Item ist ein Messpunkt. Pro Messpunkt und Lösung werden entweder 1 Punkt oder 0 Punkte vergeben.

Das Ergebnis wird auf 100 Ergebnispunkte umgerechnet. Dazu werden die erreichten Messpunkte mit 3,33 multipliziert und das Ergebnis jeweils gerundet:

Messpunkte	30	29	28	27	26	25	24	23	22	21
Ergebnispunkte	100	97	93	90	87	83	80	77	73	70

Messpunkte	20	19	18	17	16	15	14	13	12	11
Ergebnispunkte	67	63	60	57	53	50	47	43	40	37

Messpunkte	10	9	8	7	6	5	4	3	2	1	0
Ergebnispunkte	33	30	27	23	20	17	13	10	7	3	0

Die erzielten Ergebnisse werden in den Antwortbogen *Hören* eingetragen, der von beiden Bewertenden gezeichnet wird.

4.3 Modul SCHREIBEN

Die Bewertung des Moduls SCHREIBEN erfolgt durch zwei voneinander unabhängig Bewertende nach festgelegten Bewertungskriterien (s. *Modellsatz*, Teil *Prüferblätter*).

Es werden nur die vorgegebenen Punktwerte für jedes der Kriterien vergeben; Zwischenwerte sind nicht zulässig. Die für die Vergabe der Punkte relevanten Fehlgriffe etc. werden auf dem Bogen *Schreiben – Bewertung* notiert.

Im Modul SCHREIBEN sind insgesamt maximal 100 Punkte erreichbar.

Es werden nur die auf dem Bogen *Schreiben – Bewertung* vorgesehenen Punktwerte für jedes der Kriterien vergeben. Bewertet wird die Reinschrift auf dem Antwortbogen *Schreiben*.

4.2 СОНСОХ хэсэг

СОНСОХ хэсэг 30 даалгавартай. Даалгавар бүр нь нэг хэмжих нэгж. Хэмжих нэгж ба хариулт бүрт 1 эсвэл 0 оноо өгнө.

Дүнг 100 оноонд шилжүүлэн бодно. Ингэхдээ авсан хэмжих нэгжүүдийг 3.33-аар үржүүлж гарсан тоог бүхэлчлэн тооцно.

Хэмжих нэгж	30	29	28	27	26	25	24	23	22	21
Оноо	100	97	93	90	87	83	80	77	73	70

Хэмжих нэгж	20	19	18	17	16	15	14	13	12	11
Оноо	67	63	60	57	53	50	47	43	40	37

Хэмжих нэгж	10	9	8	7	6	5	4	3	2	1	0
Оноо	33	30	27	23	20	17	13	10	7	3	0

Гарсан оноог Сонсох-хариултын хуудсанд буулгаж, хоёр шалгагч гарын үсэг зурна.

4.3 БИЧИХ хэсэг

БИЧИХ хэсгийн үнэлгээг тогтсон шалгуурын дагуу хоёр шалгагч бие биеэс үл хамааран хийнэ. (Загвар шалгалт, шалгагчийн хуудас хэсгийг харна уу).

Шалгуур тус бүр өөрийн гэсэн тогтсон оноотой бөгөөд зөвхөн энэхүү өгөгдсөн оноогоор үнэлнэ. Завсрын оноог өгөхгүй. Оноо өгөхөд нөлөөлсөн алдаануудыг Бичих - Үнэлгээний хуудсан дээр тэмдэглэнэ.

БИЧИХ хэсэгт дээд тал нь 100 оноо авах боломжтой. Зөвхөн Бичих - Үнэлгээний хуудсанд тусгагдсан шалгуур тус бүрийн оноог өгнө. Бичих - Хариултын хуудсанд бичсэн бичвэрийг үнэлнэ.

Die jeweiligen Punktwerte von Bewertung 1 und Bewertung 2 werden auf den Bogen *Schreiben – Ergebnis* übertragen. Zur Ermittlung des Gesamtergebnisses wird das arithmetische Mittel aus den beiden Bewertungen gezogen und auf volle Punkte auf- bzw. abgerundet.

Eine **Drittbewertung** (= Bewertung 3) erfolgt, wenn die vergebenen Punktzahlen für das Modul SCHREIBEN der/des einen Bewertenden **unterhalb** der Bestehensgrenze und der/des anderen Bewertenden **oberhalb** der Bestehensgrenze liegen und dabei **das arithmetische Mittel** aus beiden Bewertungen **unter der Bestehensgrenze** von 60 Punkten liegt.

Das Ergebnis wird auf dem Bogen *Schreiben – Ergebnis* eingetragen.

§ 5 Bewertung Modul SPRECHEN

Die Teile 1 bis 3 zur mündlichen Produktion werden von zwei Prüfenden getrennt bewertet.

Die Bewertung erfolgt nach festgelegten Bewertungskriterien (s. *Prüferblätter*). Es werden nur die vorgesehenen Punktwerte für jedes der Kriterien vergeben; Zwischenwerte sind nicht zulässig.

Im Modul SPRECHEN sind maximal 100 Punkte erreichbar. Es werden nur die auf dem Bogen *Sprechen – Bewertung* vorgesehenen Punktwerte für jedes der Kriterien vergeben. Das Einleitungsgespräch wird nicht bewertet.

Zur Ermittlung des Ergebnisses des Moduls SPRECHEN wird aus beiden Bewertungen das arithmetische Mittel gezogen und auf volle Punkte gerundet (bis 0,49 wird abgerundet, ab 0,5 wird aufgerundet). Das Ergebnis des Moduls SPRECHEN wird auf dem Bogen *Sprechen – Ergebnis* festgehalten und als rechnerisch richtig gezeichnet. Alternativ können die Bewertungen der Prüfenden auch in eine digitale Bewertungsmaske eingegeben werden; unabhängig davon, ob eine papierbasierte oder digitale Prüfung gebucht wurde. Die Prüfenden und Bewertenden authentifizieren sich auf der Testplattform durch individuelle Login-Daten; daher entfällt die Notwendigkeit einer Unterschrift.

Үнэлгээ 1 ба Үнэлгээ 2-ыг Бичих- Дүнгийн хуудсанд шилжүүлэн бичнэ. Нэгдсэн дүнг дээрх хоёр үнэлгээний арифметик дунджаар тооцон гаргах ба гарсан тоог дээш буюу доош бүхэл тоонд шилжүүлнэ.

БИЧИХ хэсгийн хоёр үнэлгээний нэг нь шалгалтад тэнцэх босго онооноос **доогуур**, харин нөгөө нь тэнцэх босго онооноос **дээгүүр** ба энэ хоёр үнэлгээний **арифметик дундаж нь тэнцэх босго оноо болох 60 оноонд** хүрэхгүй тохиолдолд **гурав дахь шалгагчийн үнэлгээ** (=үнэлгээ 3) хийлгэнэ.

Дүнг Бичих - Дүнгийн хуудсанд шилжүүлэн бичнэ.

§ 5 Шалгалтын ЯРИХ хэсгийг дүгнэх

Аман шалгалтын 1-3-р хэсгийг хоёр шалгагч тус бүртээ үнэлнэ.

Үнэлгээг тогтсон үнэлгээний шалгуурын дагуу хийнэ (шалгагчийн хуудас хэсгийг харна уу). Шалгуур тус бүр өөрийн гэсэн тогтсон оноотой бөгөөд зөвхөн энэхүү өгөгдсөн оноогоор үнэлнэ. Завсрын оноо өгөхгүй.

ЯРИХ хэсэгт дээд тал нь 100 оноо авах боломжтой. Зөвхөн Ярих - Үнэлгээний хуудсанд тусгагдсан шалгуур тус бүрийн оноог өгнө. Танилцах оршил ярилцлага үнэлгээнд хамаарахгүй.

ЯРИХ хэсгийн дүнг хоёр шалгагчийн үнэлгээний арифметик дунджаар тооцон гаргаж, гарсан тоог бүхэл тоонд шилжүүлнэ. (0.49-аас бага буюу тэнцүү бол доош, 0.5-аас их буюу тэнцүү бол дээш бүхэл тоонд шилжүүлнэ.) ЯРИХ хэсгийн дүнг Ярих - Дүнгийн хуудсанд бичиж, дүнг зөв бодогдсоныг баталгаажуулан гарын үсэг зурна. Мөн шалгагчдын дүнг цаасан болон дижитал шалгалт авсан эсэхээс үл хамааран дижитал дүнгийн маскт тэмдэглэх боломжтой.

Шалгагчид болон үнэлгээ өгөгч нар шалгалтын платформд өөрийн нэвтрэх эрхээр орсноор гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагагүй болно.

§ 6 Prüfungsergebnisse

Das jeweilige Ergebnis der Module LESEN und HÖREN wird auf den bewerteten Antwortbögen *Lesen bzw. Hören*, das Ergebnis der Module SCHREIBEN und SPRECHEN auf den Bögen *Schreiben – Ergebnis bzw. Sprechen – Ergebnis* dokumentiert.

6.1 Ermittlung der Gesamtpunktzahl

In jedem Modul können maximal 100 Punkte = 100 % erreicht werden.

6.2 Punkte, Prozentzahlen und Prädikate

Die Prüfungsleistungen der Teilnehmenden werden für jedes Modul auf der Zeugnisvorderseite in Form von Punkten bzw. Prozentzahlen dokumentiert. Auf der Zeugniseckseite werden den Punkten Prädikate zugeordnet.

Punkte	Prädikat
100–90	sehr gut
89–80	gut
79–70	befriedigend
69–60	ausreichend
59–0	nicht bestanden

6.3 Bestehen des Moduls

Ein Modul ist bestanden, wenn mindestens 60 Punkte bzw. 60 % erreicht sind.

§ 7 Wiederholung und Zertifizierung der Module

Es gelten § 14 und § 15 der *Prüfungsordnung*.

Die Module können, sofern es die organisatorischen Möglichkeiten am Prüfungszentrum erlauben, beliebig oft abgelegt bzw. wiederholt werden.

§ 6 Шалгалтын дүн

УНШИХ, СОНСОХ хэсгийн дүнг тухайн засагдах Унших, Сонсох - хариултын хуудсанд, БИЧИХ, ЯРИХ хэсгийн дүнг Бичих - Дүнгийн хуудсанд, Ярих - Дүнгийн хуудсанд тус тус тэмдэглэн баримтжуулна.

6.1 Нэгдсэн дүнг тооцон гаргах

Шалгалтын хэсэг тус бүрт дээд тал нь 100 оноо = 100% авах боломжтой.

6.2 Оноо, хувь болон дүн

Шалгуулагчдын шалгалтын гүйцэтгэлийг хэсэг тус бүрээр сертификатын нүүрэн талд оноо буюу хувиар тэмдэглэж оруулна. Сертификатын арын нүүрэнд оноо болон түүнд харгалзах дүнг харуулсан байдаг.

Оноо	Дүн
100–90	Маш сайн
89–80	Сайн
79–70	Хангалттай
69–60	Хүрэлцэхүйц
59–0	Тэнцээгүй

6.3 Шалгалтын хэсэгт тэнцэх

Тухайн хэсэгт хамгийн багадаа 60 оноо авах буюу 60%-д хүрсэн бол тэнцсэнд тооцно.

§ 7 Шалгалтын хэсгүүдийг давтан өгөх болон сертификат авах

Шалгалтын журмын 14 болон 15-р зүйлүүд энэхүү хэсэгт үйлчилнэ.

Шалгалтын төвийн зүгээс зохион байгуулах боломжтой л бол шалгалтын хэсгүүдийг хэдэн ч удаа өгөх буюу давтан өгөх боломжтой.

§ 8 Schlussbestimmungen

Diese *Durchführungsbestimmungen* treten am 1. September 2025 in Kraft und gelten erstmals für Prüfungsteilnehmende, deren Prüfung nach dem 1. September 2025 stattfindet.

Im Falle von sprachlichen Unstimmigkeiten zwischen den einzelnen Sprachversionen der *Durchführungsbestimmungen* ist die deutsche Fassung maßgeblich.

§ 8 Төгсгөлийн журам

Энэхүү шалгалт зохион байгуулах журам нь 2025 оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд 2025 оны 9-р сарын 1-нээс хойш шалгалт өгч буй шалгуулагчдад хамаарна.

Шалгалт зохион байгуулах журмын хэлний хувилбарууд хооронд ойлголтын зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд герман хэл дээрх хувилбарыг баримтална.

Legende zu Formatierungen:

VERSAL: Prüfungsnamen und Prüfungsteile (z. B. „Modul SPRECHEN“)

kursiv: Dokumentenbezeichnungen, Eigennamen, Verweise (z. B. „Der Bogen *Schreiben – Ergebnis* wird ...“)

ANHANG

Zusätzliche Regelungen zur Durchführung digitaler Deutschprüfungen

Digitale Deutschprüfungen werden in Präsenz an einem Laptop des Prüfungszentrums des Goethe-Instituts abgelegt. Abweichend oder zusätzlich zu den oben stehenden Regelungen gilt Folgendes:

1. Abweichend von 1.2 (Prüfungsmaterialien) gilt:

Sämtliches Prüfungsmaterial der Module/Prüfungsteile LESEN, HÖREN und SCHREIBEN wird den Prüfungsteilnehmenden mittels einer Testplattform digital vorgelegt und von diesen digital bearbeitet. Die Prüfungsteilnehmenden verfassen ihre Texte mit einer deutschen Tastatur. Das digitale Material entspricht inhaltlich der papierbasierten Prüfung. Die Übertragung auf Antwortbögen entfällt, da die Prüfungsteilnehmenden ihre Lösungen und ihre Texte direkt auf der Testplattform eingeben. Eine Änderung ihrer Lösungen und ihrer Texte ist so lange möglich, bis das jeweilige Modul bzw. bei nicht-modularen Prüfungen die schriftliche Prüfung abgegeben wurde bzw. die vorgegebene Prüfungszeit abgelaufen ist.

Die Teilnehmenden können am Anfang jedes Moduls bzw. bei nicht-modularen Prüfungen zu Beginn der schriftlichen Prüfung ein Tutorial mit Erklärungen zum Umgang mit der Testplattform ansehen. Die Prüfungszeit startet erst danach.

Die Texte zum Modul/Prüfungsteil HÖREN werden direkt durch die Testplattform über Kopfhörer ausgespielt.

Beim Modul/Prüfungsteil SPRECHEN erhalten die Prüfungsteilnehmenden die Aufgaben weiterhin auf Papier.

Für alle Module/Prüfungsteile können die Prüfungsteilnehmenden bei Bedarf vom Prüfungszentrum gestempeltes Konzeptpapier erhalten.

ХАВСРАЛТ

Герман хэлний дижитал шалгалт зохион байгуулахтай холбоотой нэмэлт зохицуулалт

Герман хэлний дижитал шалгалтыг Гёте-Институтийн шалгалтын төвд зөөврийн компьютер дээр биечлэн өгнө. Дээрх зохицуулалтуудаас зөрөх заалтууд болон нэмэлтээр дараах зүйлийг мөрдөнө.

1. 1.2-н өөрчлөлт (Шалгалтын материал):

УНШИХ, СОНСОХ, БИЧИХ модуль/шалгалтын хэсгүүдийн бүх шалгалтын материалыг шалгалтын платформ ашиглан шалгуулагчдад дижитал хэлбэрээр өгч, шалгуулагчид дижитал хэлбэрээр ажиллана. Шалгуулагчид нь эхээ компьютерийн герман үсэгтэй гар ашиглан бичнэ. Дижитал материалын агуулга нь цаасан хэлбэрээр өгөх шалгалтынхтай ижил байна. Шалгуулагчид эх болон хариугаа шалгалтын платформ дээр шууд оруулдаг тул хариултын хуудсыг бөглөх шаардлагагүй. Тухайн модуль буюу шалгалтын хэсэг, модуль бус буюу хэсэгчилсэн бус шалгалтын хувьд бичгийн шалгалт өгч дуусах буюу, шалгалтын хугацаа дуусах хүртэл өөрийн хариу болон бичвэрээ өөрчлөх боломжтой.

Шалгуулагчид шалгалтын платформуыг хэрхэн ашиглах тухай тайлбар бүхий зааварчилгааг модуль бүрийн эхэнд буюу модуль бус буюу хэсэгчилсэн бус шалгалтын хувьд бичгийн шалгалтын эхэнд үзэж болно. Үүний дараа шалгалтын хугацааг тооцож эхэлнэ.

СОНСОХ модуль/шалгалтын сонсох хэсгийн эхийг чихэвч ашиглан шалгалтын платформоор шууд сонсоно.

ЯРИХ модуль/шалгалтын хэсгийн даалгаврыг шалгуулагчид цаасан хэлбэрээр хүлээн авна.

Шалгалтын бүх модуль/хэсэгт хүсэлтийн дагуу шалгуулагч нарт тамгалсан ноорог цаасыг шалгалтын төвөөс өгч болно.

2. Abweichend von § 4 (Bewertung) gilt:

Die Aufgaben mit vorgegebenen Antwortmöglichkeiten in den Modulen/Prüfungsteilen LESEN und HÖREN werden technisch automatisiert durch die Testplattform bewertet. Bei den Modulen/Prüfungsteilen SCHREIBEN und SPRECHEN werden die Bewertungen durch zwei voneinander unabhängig Prüfende/Bewertende direkt auf der Testplattform eingegeben. Die Bewertungskriterien entsprechen den Bewertungskriterien der papierbasierten Prüfung. Die Prüfenden und Bewertenden authentifizieren sich auf der Testplattform durch individuelle Login-Daten, daher entfällt die Notwendigkeit einer Unterschrift.

2. § 4-н өөрчлөлт (Үнэлгээ):

УНШИХ, СОНСОХ модуль/шалгалтын хэсгүүдэд өгөгдсөн хариултын сонголттой даалгаврын хариултуудыг шалгалтын платформоор техникийн хувьд автоматжуулсан байдлаар дүгнэдэг. БИЧИХ болон ЯРИХ модулиудын/шалгалтын хэсгүүдийн үнэлгээг хоёр шалгагч/үнэлгээ өгөгч шууд шалгалтын платформд тус бүрдээ оруулдаг. Үнэлгээний шалгуур нь цаасан хэлбэрийн шалгалтын үнэлгээний шалгууртай ижил байна. Шалгагчид болон үнэлгээ өгөгч нар шалгалтын платформд өөрийн нэвтрэх эрхээр орсноор гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагагүй болно.

Zusätzliche Regelungen zur Durchführung von Online-Deutschprüfungen

Online-Deutschprüfungen werden unter bestimmten Voraussetzungen (vgl. zusätzliche Regelungen in den Anhängen der *Prüfungsordnung* und *Durchführungsbestimmungen*) ortsunabhängig an einem privaten Desktop-Computer oder Laptop abgelegt. Für Online-Deutschprüfungen gilt Folgendes:

1. Abweichend von 1.2 (Prüfungsmaterial) gilt:

Sämtliches Prüfungsmaterial der Module/Prüfungsteile LESEN, HÖREN und SCHREIBEN wird den Prüfungsteilnehmenden mittels einer Testplattform digital vorgelegt und von diesen digital bearbeitet. Das digitale Material entspricht inhaltlich der papierbasierten Prüfung. Die Übertragung auf Antwortbögen entfällt, da die Prüfungsteilnehmenden ihre Lösungen und ihre Texte direkt auf der Testplattform eingeben. Eine Änderung ihrer Lösungen und ihrer Texte ist so lange möglich, bis das jeweilige Modul bzw. bei nicht-modularen Prüfungen die schriftliche Prüfung abgegeben wurde bzw. die vorgegebene Prüfungszeit abgelaufen ist.

Die Teilnehmenden können am Anfang jedes Moduls bzw. bei nicht-modularen Prüfungen zu Beginn der schriftlichen Prüfung ein Tutorial mit Erklärungen zum Umgang mit der Testplattform ansehen. Die Prüfungszeit startet erst danach.

Die Texte zum Modul/Prüfungsteil HÖREN werden direkt durch die Testplattform über den Lautsprecher ausgespielt.

2. Zusätzlich zu 2.1 (Vorbereitung) gilt:

2.1 Die Prüfungsteilnehmenden verwenden einen Desktop-Computer oder Laptop mit Netzbetrieb, stabiler Internetverbindung, integriertem Mikrofon, integriertem/externem Lautsprecher und integrierter/externer Webcam.

2.2 Die Tastatursprache ist auf Deutsch eingestellt.

Герман хэлний онлайн шалгалт зохион байгуулахтай холбоотой нэмэлт зохицуулалт

Герман хэлний онлайн шалгалтыг тодорхой нөхцөлийг бүрдүүлсэн тохиолдолд (шалгалтын журам, шалгалт зохион байгуулах журмын хавсралтаас нэмэлт зохицуулалтыг харна уу) орон зай харгалзахгүйгээр өөрийн суурин компьютер эсвэл зөөврийн компьютер ашиглан өгнө. Герман хэлний онлайн шалгалтад дараах заалтууд хүчинтэй. Үүнд:

1. 1.2-н өөрчлөлт (Шалгалтын материал):

УНШИХ, СОНСОХ, БИЧИХ модуль/шалгалтын хэсгүүдийн бүх шалгалтын материалыг шалгалтын платформ ашиглан шалгуулагчдад дижитал хэлбэрээр өгч, шалгуулагчид дижитал хэлбэрээр ажиллана. Шалгуулагчид нь эхээ компьютерийн герман үсэгтэй гар ашиглан бичнэ. Дижитал материалын агуулга нь цаасан хэлбэрээр өгөх шалгалтынхтай ижил байна. Шалгуулагчид эх болон хариугаа шалгалтын платформ дээр шууд оруулдаг тул хариултын хуудсыг бөглөх шаардлагагүй. Тухайн модуль буюу шалгалтын хэсэг, модуль бус буюу хэсэгчилсэн бус шалгалтын хувьд бичгийн шалгалт өгч дуусах буюу, шалгалтын хугацаа дуусах хүртэл өөрийн хариу болон бичвэрээ өөрчлөх боломжтой.

Шалгуулагчид шалгалтын платформыг хэрхэн ашиглах тухай тайлбар бүхий зааварчилгааг модуль бүрийн эхэнд буюу модуль бус буюу хэсэгчилсэн бус шалгалтын хувьд бичгийн шалгалтын эхэнд үзэж болно. Үүүний дараа шалгалтын хугацааг тооцож эхэлнэ.

СОНСОХ модуль/шалгалтын сонсох хэсгийн эхүүдийг чанга яригчаар шалгалтын платформоор шууд сонсоно.

2. 2.1-н нэмэлт (Бэлтгэл):

2.1 Шалгуулагчид тогонд холбогдсон, тогтвортой интернет холболттой, өөр дээрээ микрофонтой, өөрийн/нэмэлт өсгөгч чанга яригч, өөрийн/нэмэлт вэб камертай суурин компьютер эсвэл зөөврийн компьютер ашиглана.

2.2 Компьютерын гарыг герман хэл дээр тохируулна.

2.3 Die Prüfungsteilnehmenden stellen die Erfüllung der **technischen Voraussetzungen**, die im Folgenden sowie im Buchungsprozess aufgeführt werden, für die Prüfungsdurchführung eigenverantwortlich sicher:

Technische Voraussetzungen:

Gerät:

- Desktop-, Laptop-Computer oder Chromebook
- Sicherheitsüberprüfung und ggf. zweite Kamera: Smartphone

Monitor:

- ein Monitor oder Bildschirm
- mehrere Monitore oder Doppelbildschirme sind nicht zulässig

Lautsprecher/Mikrofon:

- interner oder externer Lautsprecher sowie ein im Computer oder der Webkamera integriertes Mikrofon
- Kopfhörer mit oder ohne eingebautes Mikrofon oder In-Ear-Kopfhörer sind nicht zulässig.

Kamera:

- Integrierte Kamera oder eine separate Webkamera
- Hinweis: Die Kamera muss so bewegt werden können, dass die Prüfungsaufsicht einen 360°-Blick auf den Raum, einschließlich der Tischoberfläche und Tischunterseite, erhält.
- Ggf. Smartphone als zweite Kamera

Browser:

- Google-Chrome™-Browser
- Browser des Dienstleisters für die virtuelle Prüfungsüberwachung wird beim Technik-Check und am Prüfungstag bereitgestellt.

Internetverbindung:

- Erforderlich: Upload- und Download-Geschwindigkeit von 5 Mbit/s
- Empfehlung: 10 Mbit/s

2.4 Unmittelbar vor der Prüfungsdurchführung müssen alle Computer-Anwendungen und Programme geschlossen sein, die nicht für die Prüfung relevant sind.

2.3 Доор дурдсан болон шалгалтыг захиалах явцад танилцуулагдах шалгалтыг явуулахад тавигдах **техникийн шаардлагуудыг** бүрэн хангах асуудлыг шалгуулагч нь **өөрөө** бүрэн хариуцна:

Техникийн шаардлагууд:

Тоног төхөөрөмж:

- Суурин компьютер, зөврийн компьютер эсвэл Chromebook
- Аюулгүй байдлын шалгалт болон шаардлагатай тохиолдолд хоёр дахь камер: ухаалаг утас

Дэлцэц:

- Монитор эсвэл дэлгэц
- Олон монитор эсвэл давхар дэлгэц ашиглахыг хориглоно.

Өсгөгч, чанга яригч/микрофон:

- Компьютерт суурилагдсан эсвэл нэмэлтээр холбогдсон өсгөгч, чанга яригч, компьютерт эсвэл вэб камерт суурилагдсан микрофон
- Микрофонтой болон микрофонгүй чихний гадуур зүүдэг чихэвч эсвэл чихэн дотор зүүдэг чихэвч хэрэглэхийг хориглоно.

Камер:

- Компьютерт суурилагдсан болон тусд нь холбосон вэб камер
- Анхааруулга: Камер нь шалгалтын хяналт тавигчид өрөөг 360°-аар харах, мөн ширээний дээд болон доод талыг харуулах боломжтойгоор хөдөлдөг байх ёстой.
- Шаардлагатай тохиолдолд: Хоёр дахь камер болгон ухаалаг утас ашиглаж болно.

Веб хөтөч:

- Google Chrome™ веб хөтөч
- Шалгалтын виртуал хяналтыг хийх веб хөтчийг техник шалгалтын үед болон шалгалт болох өдөр ашиглахаар бэлдэнэ.

Интернет холболт:

- Зайлшгүй шаардлагатай: байршуулах болон татаж авах хурд 5 Мбит/с
- Зөвлөх хурд: 10 Мбит/с

2.4 Шалгалт өгөхийн өмнө шалгалтад хамааралгүй компьютерийн бүх хэрэглээ болон программуудыг хаасан байх ёстой.

3. Abweichend von 2.2 (Ablauf) gilt:

3.1 Die Prüfungsteilnehmenden sorgen dafür, dass sie die Prüfung in einem störungsfreien Raum mit adäquaten Licht- und Sitzverhältnissen ablegen. Räume mit mehr als einer Tür oder mit großen Glasfronten sind nicht erlaubt.

3.2 Während der Prüfung befinden sich außer dem/der Prüfungsteilnehmenden keine weiteren Personen oder Haustiere im Raum, Tür und Fenster werden geschlossen.

3.3 Zur Sicherstellung, dass während der Prüfung keine weiteren Personen den Raum betreten, müssen Arbeitsplatz und Webcam so ausgerichtet werden, dass der/die Prüfungsteilnehmende und die Tür permanent im Bild sind.

3.4 Der Prüfungsplatz wird so eingerichtet, dass die Arbeitsfläche leer ist und sich außer dem Desktop-Computer mit Monitor oder Laptop, Lichtbildausweis, ggf. Tastatur und Lautsprecher keine weiteren Gegenstände auf dem Tisch befinden. Wenn der Arbeitstisch über Schubladen verfügt, müssen diese vor der Prüfung leergeäumt werden. Hierzu erfolgt eine Kontrolle.

3.5 Zur Überprüfung der Einhaltung der Prüfungsbedingungen führt die Prüfungsaufsicht zusammen mit dem/der Prüfungsteilnehmenden eine Überprüfung des Raums per Webcam durch.

3.6 Der/Die Prüfungsteilnehmende muss während der ganzen Prüfung erkennbar sein. Das Gesicht und die Ohren des/der Prüfungsteilnehmenden müssen während der gesamten Prüfung sichtbar sein und dürfen nicht verdeckt werden.

3.7 Smartwatches, analoge Uhren, Schmuckstücke im Gesichtsbereich, Haarschmuck sowie gesichtsnahe Accessoires, wie z.B. Tücher, Schals, Krawatten, dürfen während der Prüfung nicht getragen werden, um zu gewährleisten, dass keine unerlaubten technischen Hilfsmittel benutzt werden.

3.8 Mobiltelefone und weitere mobile Endgeräte müssen nachweislich ausgeschaltet und außerhalb der Reichweite des/der Prüfungsteilnehmenden deponiert werden.

3.9 Prüfungsteilnehmende verpflichten sich, die vorbereitenden Schritte zur Prüfungsdurchführung sowie die Hinweise der Prüfungsaufsicht zu beachten und Anweisungen umzusetzen.

3. 2.2-н өөрчлөлт (Шалгалтын явц)

3.1 Шалгуулагчид нь тохирсон гэрэлтүүлэг, суудал бүхий саад болох зүйлгүй өрөөг шалгалт өгөхөөр бэлдэнэ. Нэгээс олон хаалгатай эсвэл том шилэн ханатай өрөөг зөвшөөрөхгүй.

3.2.Шалгалт өгөх үед өрөөнд шалгуулагчаас өөр хүн, тэжээвэр амьтан байх ёсгүй ба хаалга, цонх хаалттай байна.

3.3 Шалгалтын үеэр өрөөнд өөр хүн орж ирээгүйг батлахын тулд вэб камерыг өрөөний хаалга, ажлын талбар болон шалгуулагч нь өөрийгөө байнга харагдаж байхаар байршуулна.

3.4 Шалгалтын байрыг ажлын талбар хоосон байхаар, ширээн дээр дэлгэц бүхий суурин компьютер, зөөврийн компьютер, зураг бүхий үнэмлэх, компьютерийн гар, өсгөгч зэргээс өөр зүйл байхгүй байхаар зассан байна. Хэрэв ажлын ширээ нь шургуулгатай бол шалгалтын өмнө тэдгээрийг хоослох ёстой. Эдгээр шаардлагыг хангасан эсэхийг шалгана.

3.5 Шалгалтын өрөө нь шалгалт өгөх нөхцөлийг бүрдүүлсэн эсэхийг хянагч веб камер ашиглан шалгуулагчтай хамтран баталгаажуулна.

3.6 Шалгуулагч нь шалгалтын туршид танигдахуйц байх ёстой. Шалгуулагчийн нүүр, чих нь шалгалтын турш харагдахуйц байх ёстой бөгөөд ямар нэг хэлбэрээр халхлахыг хориглоно.

3.7 Шалгалтын явцад зөвшөөрөлгүй техникийн хэрэгсэл ашиглагдахаас сэргийлж аливаа ухаалаг цаг, аналог цаг, нүүрний гоёл чимэглэл, үсний гоёл чимэглэл, хүзүүний алчуур, ороолт, зангиа зэрэг нүүрэнд ойр байх зүйлс зүүхийг хориглоно.

3.8 Гар утас болон бусад зөөврийн хэрэгслийг унтраан шалгуулж, шалгуулагчийн гар хүрэхгүй газар байрлуулна.

3.9 Шалгуулагчид шалгалт явуулах бэлтгэл үе шат, мөн шалгалтын хянагчийн өгч буй зааварчилгааг анхаарч, дагаж мөрдөх үүрэгтэй.

3.10 Der schriftliche Teil der Online-Deutschprüfung findet als Einzelprüfung statt. Der Prüfungsteil/Das Modul SPRECHEN wird abhängig von den Gegebenheiten am Prüfungszentrum entweder als Einzel- oder Paarprüfung durchgeführt.

Die zeitliche Organisation der Prüfung erfolgt gemäß 1.4.: Falls während der schriftlichen Prüfung ein Toilettengang erforderlich ist, wird der Zeitplan beibehalten und die Prüfungszeit nicht verlängert.

4. Abweichend von § 4 und § 5 (Bewertung) gilt:

Die Aufgaben mit vorgegebenen Antwortmöglichkeiten in den Modulen/Prüfungsteilen LESEN und HÖREN werden technisch automatisiert durch die Testplattform bewertet. Bei den Modulen/Prüfungsteilen SCHREIBEN und SPRECHEN werden die Bewertungen durch zwei voneinander unabhängig Prüfende/Bewertende direkt auf der Testplattform eingegeben. Die Bewertungskriterien entsprechen den Bewertungskriterien der papierbasierten Prüfung (siehe dazu § 4 und § 5). Die Prüfenden und Bewertenden authentifizieren sich auf der Testplattform durch individuelle Login-Daten, daher entfällt die Notwendigkeit einer Unterschrift.

3.10 Герман хэлний онлайн шалгалтын бичгийн хэсэг ганцаарчилсан хэлбэрээр явагдана. Шалгалтын ЯРИХ хэсэг/модуль тухайн нөхцөл байдлаас шалтгаалан шалгалтын төвд ганцаарчилсан эсвэл хосоор орохоор явагдана.

Шалгалт үргэлжлэх хугацааг 1.4-т заасны дагуу зохион байгуулна: Бичгийн шалгалтын үеэр ариун цэврийн өрөө орох шаардлагатай тохиолдолд цагийн хуваарийг баримталж, шалгалтын хугацааг сунгахгүй.

4. § 4 ба § 5-н өөрчлөлт (үнэлгээ):

УНШИХ, СОНСОХ модуль/шалгалтын хэсгүүдэд өгөгдсөн хариултын сонголттой даалгаврын хариултуудыг Шалгалтын платформоор техникийн хувьд автоматжуулсан байдлаар дүгнэдэг. БИЧИХ болон ЯРИХ модулиудын/шалгалтын хэсгүүдийн үнэлгээг хоёр шалгагч/үнэлгээ өгөгч шууд шалгалтын платформд тус бүрдээ оруулдаг. Үнэлгээний шалгуур нь цаасан хэлбэрийн шалгалтын үнэлгээний шалгууртай ижил байна. Шалгагчид болон үнэлгээ өгөгч нар шалгалтын платформд өөрийн нэвтрэх эрхээр орсноор гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагагүй болно.